

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРААС 2014 ОНД  
ХИЙГДЭЖ БАЙГАА ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ЯВЦААС:**

№	Хийсэн ажлын нэр	Үр дүн
1	<p>Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 06 дүгээр сарын 24-ны өдрийн удирдамжаар “Эрчим хүчний хөгжлийн төв” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, төрийн албан хаагчдын ажлын чиг үүргийн давхардлыг арилгах, зардал бууруулахад чиглэсэн дүгнэлт гаргах” зорилгоор дотоод аудит хийх.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Эрчим хүчний Төсвийн төвлөрүүлэн захирагч болон шууд захирагчийн ажлын албаар бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын ажлын төсөв – зэргийг хянуулдаг болгох талаар “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨААТҮГазрын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан.</li> <li>2. Орон тооны хувьд ажлын ачаалал хэт хөнгөн, өдөр тутмын биш, өөр ажилтануудын ажлын байрны тодорхойлолтод нэмж болохуйц 5-н орон тоог цомтгох шийдвэр гаргуулах талаар Төрийн нарийн бичгийн даргад саналыг хүргүүлсэн.</li> <li>3. Төвийн захиралын хүчин төгөлдөр бус тушаалаар байгуулагдсан хэвлэлийн цехийн үйл ажиллагаа нь алдагдалтай ажиллаж байгаа , мөн цехийн тоног төхөөрөмж нь гар болон механик ажиллагаатай тул хүчин чадлын хувьд шаардлага хангахгүй тоног төхөөрөмжийг 77,0 сая төгрөгөөр /өндөр үнээр/ худалдан авсан зөрчлийг шалгалтаар илэрүүлсэн.</li> <li>4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх.</li> </ol>
2	<p>Эрчим хүчний сайдын 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 92 дугаар тушаалаар “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ний 2012-2014 оны хөрөнгө оруулалт, их засварын ажлын гүйцэтгэлийн үр дүн, санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналтын хэрэгжилтийн байдалд санхүүгийн дотоод аудит”-ыг хийж гүйцэтгэх.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулан мөрдөж ажиллах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх.</li> <li>2. Гүйцэтгэх захиралын хүчин төгөлдөр бус тушаалууд , ерөнхий нягтлан бодогчын хууль бус үйлдлээс үүдсэн нийт 43,8 сая төгрөгийг буцаан төлүүлж компанийг хохиролгүй болгож нөхөн төлүүлэхээр;</li> <li>3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаал, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалыг тус зөрчиж ажиллагсдын ээлжийн амралтын мөнгийг буруу тооцож 29,7 сая төгрөг дутуу олгосоныг буцаан олгуулах;</li> <li>4. Ерөнхий нягтлан бодогч нь нийт 66.9 сая төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтгүйгээр дансий бичилтийг санаатайгаар буруу хийж, санхүүгийн тайлан тэнцлийг буруу гаргаж хувьцаа эзэмшигчдэд ташаа мэдээлэл өгсөн зөрчилд хариуцлага тооцуулах;</li> <li>5. 2013-2014 оны эхний хагас жилд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйн улмаас үүдэн гарсан нийт 1,05 тэрбум</li> </ol>

		<p>төгрөгийн зөрчлүүдийг хуулийн байгууллагад шилжүүлэх;</p> <p>6. Компанийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4, 3 дугаар зүйлийн 3.1.4, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10 дахь заалт, Эрчим хүчний салбарын 2013-2014 оны хамтын хэлэлцээрийн зүйл заалтыг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцуулах – зэрэг асуудлыг ТЕЗ-ын дэргэдэх Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх</p>
3	<p>Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн удирдамжаар Сэлэнгэ аймгийн “ ОНӨААТҮГазрын санхүүгийн тайланд санхүүгийн шинжилгээг хийх, санхүүгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, станцын одоогийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн байдалд дүгнэлт гаргах, мөн үйлдвэрийн газрын менежментийн байдалд дүн шинжилгээ хийх.</p>	<p>“Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГазрын үйлдвэрлэлт болон санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн шинжилгээ, судалгаагаар тус үйлдвэрийн менежментийг боловсронгуй болгох, сайжруулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтанд тавих хяналтыг сайжруулахад Төрийн өмчийн мэдэлд авах шаардлагатай болсон байна гэсэн дүгнэлт гаргаж Эрчим хүчний сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын шийдвэр гарсан тохиолдолд Төрийн өмчийн мэдэлд авах талаар албан бичгийг явуулсан.</p>
4	<p>Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар “Эрчим хүчний салбарын санхүү бүртгэлийн ажилтны семинар-2014”-ийг зохион байгуулах</p>	<p>Сургалтанд Сангийн яам, Үндэсний аудитын газар, Татварын ерөнхий газар, Төрийн өсчийн хороо – зэргээс холбогдох мэргэжилтэнүүдийг урьж хичээл заалгаж зөвлөмж хүргүүлж ажилласан.</p>
5	<p>“Эрчим корпораци” ТӨААТҮГ-ын 2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийх.</p>	<p>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх.</p> <p>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 300,0 мянган төгрөгийн зөрчил гарсныг дахин гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлсэн.</p>
6	<p>Сангийн яамны Сайдаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Аудитын хороог байгуулж ажиллах талаархи зөвлөмж</p>	<p>Эрчим хүчний сайдын 2014 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 63 дугаар тушаалаар Дотоод аудитын хороог байгуулсан.</p>